

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НОМЫН САН



ШИНЭ НОМЫН

2017.10.30

№ 03

ЭМХЭТГЭСЭН:

Номзүйч М. Кунай

Номзүйч М. Намжилмаа

Электрон каталог:
<http://catalog.num.edu.mn>

БАЙГАЛИЙН УХААН

ГЕОДЕЗИЙН ШИНЖЛЭХ УХААН. ЗУРАГ ЗҮЙ



Дамдинсүрэн А. ба бус. **Геодези:** Тэргүүн дэвтэр /А.Дамдинсүрэн, Ж.Алтанцэцэг, Б.Рагчаа; Ред. Ж.Алтанцэцэг.-3дахь хэвл. -УБ.: <Хэвлэлийн газар байхгүй>, 2017.- 167х. - ISBN: 978-99978-0-223-1.

Энэ сурах бичигт одоо манай геодезийн үйлдвэрлэлд хэрэглэгдэж байгаа солбилцол, өндрийн тогтолцоо, геодезийн хэмжилт, зураглал хийх аргуудыг тодорхой дурьдсаны дээр сүүлийн жилүүдэд геодезийн хэрэглэгдэж байгаа гэрлэн ба электрон зай хэмжүүрүүд, тоон зураглалын арга, электрон тахеометрүүд зэрэг техник технологийн тухай тусган оруулжээ. Түүнчлэн “Геодези” хичээлд хэрэглэгддэг

латин болон грек үсгүүд, тригнометрийн томъёонуудаас гадна сурах бичигт хамрагдсан зарим үгийн тайлбарыг орос орчуулгын хамт оруулжээ.

26.1я73

Д-27

/БУН унш-8ш, ГНОФ-10ш/

Т-18887-18889

Дамдинсүрэн А. **Геодезийн нэр томъёоны тайлбар толь** / Ред. Д.Болормаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2013.- 123х.- (ШУТИС-УУИС).- ISBN 978-99973-2-157-2.


Уг тайлбар толийг геодезийн болон геодезийг хэрэглэдэг бүх салбарт ажиллаж буй мэргэжилтнүүд, энэ чиглэлээр суралцаж буй оюутан залуус, сонирхсон бүх хүмүүст зориулан гаргажээ. Энэхүү тайлбар толь бичигт одоо манайд хэрэглэгдэж байгаа ихэнхи үг хэллэгүүд багтсан. Тайлбар толь нь цаашид геодези, зурагзүйн лавлахууд гаргахад дөхөм болно гэж үзжээ.

26.1я2

Д-27

/БУН унш -7ш/

Б-24850-24852



Дамдинсүрэн А., Алтанцэцэг Ж. **Геодезийн хэмжилт боловсруулалтын ажлууд:** Тэргүүн дэвтэр / Ред. Ж.Алтанцэцэг.- 6 дахь хэвл.- УБ., 2015.- 175х.- (ШУТИС-УУИС).- ISBN 999292-3-105-1.

Энэхүү сурах бичгийг “Геодези ” хичээлийг эхлэн судалж байгаа оюутнуудад зориулан геодезийн шинжлэх ухааны үндсэн ойлголтуудтай танилцах, газрын зураг дээр ажиллаж сурах, геодезийн хэмжилтийн багаж хэрэгсэл, арга зүй, боловсруулалтын онолыг судлах, том масштабын байр зүйн зураглал үйлдэх,

боловсруулах дадал чадварыг эзэмшихэд туслах зорилгоор бэлтгэн гаргажээ. Авто зам, барилга зэрэг инженерийн төрөл бүрийн салбаруудад өргөн хэрэглэгддэг геодезийн зарим төрлийн ажлуудын талаар тусгасан тул энэ чиглэлээр суралцаж байгаа оюутнууд хэрэглэх боломжтой юм.


26.12я73

Д-27

/БУН унш -7ш/

Б-24853-24855

ГЕОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Монгол-Сибирийн геотрансект: Монгол-Сибирийн бүс нутаг дахь дэлхийн царцдасын структур ба палеогеодинамик / Турутанов Е.Х., Зорин Ю.А., Скляр Е.В ба бус.; Ред. О.Төмөртоого; Орч. Н.Арвисбаатар.- УБ.: ШУТИС, 2016.- 132х.- (МУ-ын ШУА.ОХУ-ын ШУА. Монгол-Оросын хамтарсан эрдэм шинжилгээний геофизикийн экспедиц).- ISBN 978-99962-55-73-1.

Төв Азийн атираат бүслүүрт байрлах Монголын газар нутаг, дэлхийн геологийн хөгжлийн түүхийг тольдож болох нэн таатай хосгүй талбарын нэг билээ. ШУА-ийн Монгол-Оросын хамтарсан эрдэм шинжилгээний геофизикийн экспедиц 1986-1992 онуудад Монгол орны гүний тогтцын геофизикийн нэгдсэн судалгааг хэрэгжүүлсэн бөгөөд голлох үр дүнг нь энэхүү бүтээлд толилуулжээ. Тус бүтээл, Монгол- Сибирийн бүс нутгийн гүний тогтоц, палеогеодинамикийг сонирхогч геологи, геофизикийн судлаач мэргэжилтэн, оюутан нарт зориулагджээ.

26.3

М-69

/БУН унш-5ш/

Т-19059-19060

Ухнаа Г. ба бус. **Геологийн судалгааны математик арга** / Б.Алтанзул, И.Цогхүү; Хян. Д.Алтанхуяг.- 2 дахь хэвл.- УБ.: ШУТИС., 2017.- 166х.- (МУ-ын ШУТИС.ГУУС).-ISBN 978-99978-0-684-0.



Энэхүү номыг ШУТИС-ийн ГУУС-ийг геологи, ашигт малтмалын эрэл хайгуул мэргэжлээр бакалврын зэрэг горилон төгсөж буй ирээдүйн геологичдыг хайгуулын ажлын үр дүнгийн тооцоонд статистик шинжилгээ хийх аргачлалд мэргэшүүлэн дадлагажуулах зорилгоор боловсруулжээ. Сурах бичигт математик статистик, геостатистикийн аргын онолын үндсийг тайлбарлахын зэрэгцээ олон тооны жишээн дээр бодолт хийж дүгнэлт гаргасан.

26.3

У-61

/БУН унш-3ш, ГНОФ-10ш/

Т-19057-19058



Ухнаа Г. ба бус. **Алт:** Ордын геологи, эрэл, хайгуул / Г.Дэжидмаа, О.Ганцэцэг; Хян. Б.Алтанзул.- УБ.: ШУТИС., 2017.- 450х.- ISBN 978-99978-0-575-1.


Хүн төрөлхтөний хэрэглээнд орсон анхны металлуудын нэг болох алт хэмээх энэхүү үнэт металл нь физик, химийн олон гайхамшигт чанараараа өнөөгийн шинжлэх ухаан, технологийн эрин үед улам илүү ач холбогдолтой болж байна. Энэхүү бүтээл нь 4 бүлэгтэй, эхний бүлэгтээ алтны үндсэн ордын геологийн ангиллуудыг багтаасан бол; 2-р бүлэгтээ алтны ордуудын эрлийн шинж тэмдэг ба шалгуурууд; 3-р бүлэгтээ хайгуулын аргачлал, сорьцолт, нөөцийн тооцооллын онол, арга зүйн асуудлын талаар; 4-р бүлэгтээ хайгуулын ажлыг чанартай хийсэн алтны зарим ордын геологи, хайгуулын ажлын жишээг оруулжээ.

26.34

У-61

/БУН унш-3ш, ГНОФ-5ш/

Б-24960-24961



Алтанболд Э., Одхүү Н. **Монголын ашигт малтмалын газарзүйн байршлыг хэн сайн мэдэх вэ?** / Ред. Х.Уламбадрах, З.Ганбаатар.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 96х.- ISBN 978-99978-0-551-5.

Энэхүү бүтээл нь үндсэн 5 хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэгт чулуулгийн гарал үүслээр

нь ангилж түүний харагдах хэлбэр, өнгө дүрсийг ажиглан танин мэдэх, тогтоох, практикт ашиглах боломжийг эрэлхийлжээ. Дараагийн хэсгүүдэд Монгол оронд одоогоор тогтоогдоод буй метал бус болон шатах ашигт малтмалын сав, дүүрэг, зангилаа, орд, илрэлүүдийн газарзүйн байршлыг тэмдэглэжээ. Сүүлийн хэсэгт ашигт малтмалтай холбоотой орчин үеийн олон улсын болон Монгол улсын албан ёсны эх сурвалжуудыг ашиглаж зохиосон сонирхолтой тест, дасгал ажлуудыг багтаасан нь шинэлэг болжээ. Энэхүү номонд багтсан даалгаврууд нь зөвхөн мэдлэгээ шалгах бус шинээр мэдээлэл, мэдлэг олж түүнийгээ боловсруулах, ашиглахад чиглэгдсэн бүтээл болжээ.

26.34(1)

A-48

/БУН-7ш, ГНОФ-10ш/

T-18890-18892

ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Газар зүйн мэдээллийн системийн үндэс: Сурах бичиг/ Rolf A. de By; Yola Georgiadou; Richard A. Knippers; Menno-Jan Kraak; Yuxian Sun; Micheal J.C. Weir; Cees J.van Westen. -2дахь хэвл.- УБ.: МУИС Пресс, 2016.-345х.- (Дэлхий Судлал ба Газарзүй Мэдээллийн Системийн Олон Улсын Институт) -ISBN: 978-99973-3-220-2. Газар зүйн мэдээллийн системийн анхан болон дунд шатны сургалтанд ашиглах зориулалттай энэ номонд байгалийн олон янзын үзэгдлийн талаар дурдаж, тэдгээр юмс үзэгдлийг газар зүйн мэдээллийн системийн тусламжтайгаар хэрхэн дүрсэлж болох, газар зүйн мэдээлэл, өгөгдөл боловсруулах систем, орон зайн мэдээний чанар, дэлхийн орон зайг тодорхойлогч тогтолцоо, байршлын алдаа болон хиймэл дагуулд суурилсан байршил тогтоох систем, мэдээг цуглуулах, системд оруулах, хэрэглээнд бэлтгэх, мэдээг хэрхэн ойлгомжтой, энгийн байдлаар дүрслэн харуулж болох талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, логик дэс дараалалтай, энгийнээр тайлбарлажээ.

26.82я73

G-16

/БУН унш-12ш, ГНОФ-5ш/

T-18893-18895



РАДИО ЭЛЕКТРОНИК



Махгал Г., Мөнгөнсүх Ш. **Статистик програмчлалын R хэл:** Анхан шатнаас мэргэжлийн түвшинд /Ред. Б.Магсаржав.- УБ.: Адмон, 2017.-210х.- ISBN: 978-99978-0-753-3.

R хэл нь орчин үеийн статистикчдын эзэмшсэн байх үндсэн мэдлэг чадваруудын нэг болсон бөгөөд дэлхий дахинд түүний хэрэглээ цаашид ч өсөн нэмэгдэх хандлагатай байна. Энэхүү номыг ажиглан статистик програмчлалын R хэлийг бие даан сурч эзэмшихэд танаас програмчлалын хэлний ямар нэгэн суурь мэдлэг үл шаардах бөгөөд статистикч таны ширээний ном байх болно.

32.973-018.2

M-30.

/БУН унш-12ш, ГНОФ-5ш/

T-19040-19042

ХИМИЙН ТЕХНОЛОГИ. ХИМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Эрдэнэбат Ц. **Цемент, бетоны хими**: Мэргэжилтнүүдийн гарын авлага /Хян. Г.Самдан. -Анхны хэвл.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 220х.(МУИС.ХШУИС. Шинэ материал судлалын төв).-ISBN: 978-99978-0-651-2.


Энэхүү бүтээл нь бетоны жигд бөгөөд бат бэх орших шинж чанарууд нь хэрхэн цементийн шинж чанар ба онцлогоос үндсэндээ хамаардаг талаар өгүүлнэ. Портланд цемент нь дэлхий дээрх хамгийн түгээмэл хэрэглэгддэг цементийн төрөл бөгөөд түүнчлэн газрын хөрсийг тогтворжуулах зарим тохиолдолд хаягдлыг хатууруулж тогтворжуулах болон газрын тосны ордын ашиглалт зэрэгт мөн өргөнөөр ашиглагддаг байна.

35.41я7

Э-73

/БУН унш-8ш, ГНОФ-5ш/

T-19053-19054



Самдан Г. **Сульфоалюмоферритлэг цемент, түүнд тулгуурласан тусгай зориулалтын цемент гарган авах хими технологийн үндэс**.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 219х.- ISBN 978-99978-0-631-4.

Энэ номонд монгол орны цементийн үйлдвэрүүдэд хэрэглэж байгаа үндсэн түүхий эд, сульфоцемент гаргаж авах түүхий эд, байгалийн түүхий эд, үйлдвэрийн хаягдал ашиглаж эрдэсжүүлсэн цемент ба идэмхий орчинд тэсвэртэй, өндөр маркийн холимог цемент гаргаж авах, мөн тусгай зориулалтын цагаан цемент, галд тэсвэртэй цемент, идэмхий орчинд тэсвэртэй сульфатжуулсан өндөр маркийн цемент

үйлдвэрлэх, үйлдвэрт туршсан ажлын үр дүнгийн үзүүлэлтүүдийн талаар өгүүлжээ.

35.41

C-25

/БУН унш-3ш/

T-19090-19091



Ерөнхий хими / П.Мөнхбаатар, Б.Бямбагар, Ж.Бүдсүрэн ба бус; Ред. П.Мөнхбаатар.- УБ.: ШУТИС хэвлэлийн газар, 2017.- 496х.- ISBN 978-99929-2-725-0.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн инженер технологийн болон бусад их дээд сургуулиудын химийн бус мэргэжлийн ангийн оюутнуудад зориулагдсан энэ номонд химийн ухааны судлах зүйл, үндсэн ойлголт, атом молекул, химийн нэгдлүүд, химийн урвал, усан уусмалд явагдах урвалууд, хийн хуулиуд, орбиталууд, үелэх систем, химийн холбоо түүний төрлүүд, бодисын төлөв байдал, хүчил, чөлөөт

энерги, цахилгаан үүсгүүр, металл биш элементүүд, цөмийн төрлүүд, химийн үйлдвэрлэлийн талаар дэлгэрэнгүй, ойлгомжтой бичжээ.

24.1

E-70

/БУН унш-3ш, ГНОФ-5ш/

T-18818-18819

ОЙН АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН

Пунсалдулам Б. **Монголын газар тариалангийн түүх**: Тэргүүн дэвтэр: 1900-1958 / Хян. Ж.Урангуа.- УБ.: Бэмби сан, 2017.- 212х.- ISBN 978-99978-0-595-9.

Зохиогч XX зууны эхний 60-аад жилийн газар тариалангийн хөгжлийн түүхийг судлахдаа төрөөс газар тариалангийн талаар баримталсан чиг бодлого, түүнийг



амьдралд хэрэгжүүлсэн арга хэлбэр, байгаль газар зүйнхүчин зүйлс, техник технологийн ололт, боловсон хүчин, инженер-агрономчдын хагамж зэрэг асуудлыг нэлээд цогц байдлаар шинжлэн авч үзжээ. Зохиолын энэхүү тэргүүн дэвтэр нь он цагийн хувьд 1900-1958 оныг хамарч байна.

41.4(1)

П-88

/НУН унш-8ш/

Т-19082-19084



Монгол орны ойн таксацын лавлах /Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав, З.Цогт, Г.Цэрэндаш, Ц.Чулуунбаатар; Ред. Ж.Цогтбаатар, Н.Баатарбилэг. -УБ.: Бэмби сан, 2012.-263х. - ISBN: 978-99962-3-134-6.

Монгол орны ойн таксацын лавлах бүтээлд Монгол орны ойн ургамалжлын мужлал, ойн өндрийн бүслүүрийн онцлог, ойн үндсэн хэв шинжийн тодорхойлолт, ойн таксацийн бүртгэл тооллого хийх, түймрийн аюулыг үнэлэх аргачлал, тодорхой бүс нутгийн хэмжээнд боловсруулсан модны эзлэхүүний ба өсөлтийн явцын хүснэгт, ишний бүдүүний үеллээр хэрэгцээний модны гарцыг тодорхойлох таваарын болон сортиментийн хүмнэгт зэргийг багтаасан бөгөөд ойн салбарын байгууллага,

мэргэжилтэн, багш, оюутан нарт зориулав.

43.4(1)я2

М-69.

/БУН унш-12ш/

Т-18885-18886,19426-19430

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН



Ганхуяг Д. **Монголчууд та нар юу юм?!: Боть-I** (2008-2010 он).- УБ.:Мөнхийн үсэг, 2016.-570х. -ISBN: 978-99973-58-42-4.

Судлаач Х.Д.Ганхуяг 2,400,000 хандалттай Монголын хамгийн том блог хөтөлдөг бөгөөд нийгмийн зөрчилт асуудал болгоныг судалж, системийн шинжилгээ хийж сардаа 8-12 өгүүлэл бичдэг ажээ. Өөрийнхөө бичсэн судалгаа, шинжилгээний өгүүллүүдээ оноор нь ялган эмхэтгэж 3 боть болгон толилуулж байна. Энэ 1-р ботид “Төр хийгээд бидний эрсдэл”, “Төргүй хууль, хуульгүй төр”, “Оюуны хулгайгаа болиоч ээ...”, “Сонгууль болгон луйвраар эхлэх ёстой юу?”, “Цагаан

хэрээ”, “Залуу судлаачдад өгөх зөвлөмж №1-11”, “Орденгоос одон хүртэл”, “Удирддаг юмыг төр гэдэг”, “Чимээгүй сонгууль”, “Энхбаяризмын сүүлчийн оролдлого”, “76 Тэрбумын төр”, “Бүгдээрээ саятан болцгооё”, “Панмонголизм”, “Өөдрөг үзэл”, “Үнс үү алт уу”, “Хувалз-1” зэрэг 100 гаруй өгүүллүүд оржээ.

60.(1)

Г-23

/НУН унш-7ш/

Т-18847-18849

Ганхуяг Д. **Шинжлэх ухаан наашаа луйварчид цаашаа:** Боть-II (2011-2013 он).- УБ.: Мөнхийн үсэг, 2016.-818х. -ISBN: 978-99973-58-43-1.

Судлаач Х.Д.Ганхуяг 2,400,000 хандалттай Монголын хамгийн том блог хөтөлдөг бөгөөд нийгмийн зөрчилт асуудал болгоныг судалж, системийн шинжилгээ хийж сардаа 8-12 өгүүлэл бичдэг ажээ. Өөрийнхөө бичсэн судалгаа, шинжилгээний өгүүллүүдээ оноор нь ялган эмхэтгэн 3 боть болгон толилуулж байна. Энэ 2-р ботид “Бас нэг нууц гэрээ”, “Дээрэмчдийн нам мандтугай”,



“Уранаар хутгасан бантан”, “Хувьцааныхаа үнэтэйг хулхидуулахаараа мэднэ”, “Цөмийн хаягдал нь аль эртнийх”, “Жолооны ардах архи”, “Монголд сонгууль л болдог”, “Монголыг тойрсон нүүрс”, “Муусайн олигархууд”, “Социализмаас авсан юм”, “Монгол менталитет”, “Баабар балайтах тоолонд”, “Монгол банкны доромжлол”, “Хасбуу тамга хаа байна”, “Хулхихдах урлаг”, “Энхбат бид хоёрын маргаан” зэрэг 200 гаруй өгүүллүүд оржээ.

60.(1)

Г-23

/НУН унш-7ш/

T-18850-18852



Ганхуяг Д. **Монгол улс том уу жижиг үү**: Боть-III (2014-2016 он).- УБ.: Мөнхийн үсэг, 2016.-838х. -ISBN: 978-99973-58-45-5.

Судлаач Х.Д.Ганхуяг 2400 000 хандалттай Монголын хамгийн том блог хөтөлдөг бөгөөд нийгмийн зөрчилт асуудал болгоныг судалж, системийн шинжилгээ хийж сардаа 8-12 өгүүлэл бичдэг ажээ. Өөрийнхөө бичсэн судалгаа, шинжилгээний өгүүллүүдээ оноор нь ялган эмхэтгэн 3 боть болгон толилуулж байна. Энэ 3-р ботид “Rio tinto юу хийж байна”, “Америк зан”, “Бүдүүлэг залуучууд”, “Зэсийн асуудал босч ирэв”, “Монгол банкны маапаан”, “Намын нэр төр”, “С.Баярын түүхий хоол”, “Хятад ухаан”, “Элсний 13 гэж...”, “Золиос ба хүлээс”, “Монгол тийм муухай юу..”, “Үндэстнээ аварсан санхүүчид”, “Хаос хийгээд улс мөхөөх технологи”, “Хэлмэгдэл гэж..”, “Цэвэр соёл хийгээд монгол хэл соёлын тухайд”, “АН-ын тэнэг зодоон”, “Далд засаглал”, “Өрөг ба хориг”, “Ч.Сайханбилэгийн компанийн засаглал”, “МАН-д болсон явдал”, “Эвсэхийн зовлон”, “Хутга тулгасан эв нэгдэл” зэрэг 150 гаруй өгүүллүүд оржээ.

60.(1)

Г-23

/НУН унш-7ш/

T-18853-18855

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баярсайхан Д. **Хүлэгэ хаанаас абу са ид хүртэл**: Ил-Хаадын тухай өгүүллүүд / Ред. Ж.Ичинхорлоо.- УБ.:МУИС., 2016.- 245х.- ISBN 978-99973-42-82-9.

Энэхүү ганц сэдэвт зохиолоор ил-хаадын улс төрийн түүхийг ил-хаад тус бүрийн бие хүний онцлог, Иран болон Кавказ, Бага Ази, Афганистан, Сири, Палестины нутгийг захирч байсан зарим монголчуудын тухай товч өгүүлсэн. Толь бичигт газар шим ертөнц, хүний бие эрхтний бүтэц, цаг хугацаа, орон зай, он тоолол, улирал, газар зүй, нэхмэл сүлжмэл, бөс бараа, ургамал, амьтан, хоол хүнс, өнгө будаг, зэр зэвсэг, тооны ухаан зэргийг агуулсан өргөн хүрээний үгс, нэр томъёог зургаан хэлнээ зүйлчлэн оруулжээ.

63.3(1)

Б-38

/НУН-унш-3ш, ГНОФ-10ш/

Б-24878-24879



Ил-Хаадын судлал шинэ хандлага: Өгүүллийн эмхэтгэл / Эрхл. Д.Баярсайхан, П. Атвуд; Ред. Ж.Ичинхорлоо.- УБ.: МУИС., 2017.- 485х.- ISBN 978-99973-42-83-6.

Ил-хаадын судлал: шинэ хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан нь тухайн мэргэжлийн эрдэмтдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, Монгол улс дахь Ил-хаант улсын судлалд чухал түлхэц болсон. Тус хуралд АНУ, Их Британи, Израиль, Итали, Япон, Хятад, Монгол зэрэг улсын эрдэмтэд оролцож, Ил-


хаант улсын засаг захиргаа, төрийн бодлого, гадаад харилцаа, түүхэн сурвалж бичгийн тухай хорь гаруй илтгэл хэлэлцүүлсэн нь Ил-хаант улсын түүхийн судлалд үнэтэй хувь нэмэр болж чадсан.

63.3(1)42+72

И-43

/НУН унш-3ш, ГНОФ-5ш/

Б-24880-24881



Дэлхийд түгсэн Монголын нууц товчоон / Ред. М.Баярсайхан, З.Заяабаатар, Э.Пүрэвжав; Англи хэлнээс орч. Д.Отгонтуяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 288х.- ISBN 978-99929-2-530-0.

Дэлхий дахинд гарсан “Монголын нууц товчоо”-ны судалгааны бүтээл, орчуулга хөрвүүлэг, хялбаршуулсан 200 гаруй номыг энэ бүтээлд хамруулсан бөгөөд номын тайлбарыг кирил, монгол бичгээр бэлтгэхийн зэрэгцээ англи хэлээр орчуулж, зарим бүтээлийн галиг, хөрвүүлэг, орчуулгын онцлогийг тодорхой харуулах үүднээс “Монголын нууц товчоо”-ны нэгдүгээр зүйлийг үлгэр болгон хавсаргажээ. Мөн уг сурвалж бичгийн холбогдолтой марк, тэмдгийг хавсарган оруулжээ.

63.3(1)я2

Д-89

/НУН унш-7ш, ГНОФ-10ш/

Т-19087-19089

Монголын эртний түүх: 5 боть / Ред. П.Дэлгэржаргал, Б.Батсүрэн.- 2 дахь хэвлэл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- (МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. МУИС-ийн түүхийн тэнхим. ШУА-ийн түүх археологийн хүрээлэн.)

2016 онд МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн, МУИС-ийн түүхийн тэнхимд хэрэгжүүлсэн “Монголын эртний түүх” хэмээх төслийн хүрээнд энэхүү 5 боть бүтээлийг хэвлүүлсэн ба 1-р ботид П.Дэлгэржаргал, З.Батсайхан нарын “Хүннү”, 2-р ботид П.Дэлгэржаргалын “Сяньби”, 3-р ботид С.Өлзийбаяр, А.Энхбат нарын “Жужан”, 4-р ботид Б.Батсүрэн, Р.Мөнхтулга нарын “Түрэг, Уйгур”, 5-р ботид Б.Батсүрэн, Б.Чинзориг, Э.Жигмэддорж нарын “Төв Азийн нүүдэлчдийн төр улсууд” бүтээлүүд оржээ. “Монголын эртний түүх” хэмээх энэхүү цуврал 5 боть бүтээлд Монголын эртний улсууд болох Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Уйгур, Татар, Хятан нарын угсаа гарвал, улс төр, төр-нийгмийн байгуулал, аж ахуй, соёлын түүхийг анх удаа 5 ботиор нэгтгэн харуулжээ.

63.3(1)4

М-69

/НУН унш-7ш, ГНОФ-20ш/

Б.1.- 252х.- ISBN978-99978-58-03-0.

Т-19064-19066

Б.2.- 227х.- ISBN978-99978-58-07-8.

Т-19067-19069

Б.3.- 229х.- ISBN978-99978-58-05-4.

Т-19070-19072

Б.4.- 250х.- ISBN978-99978-58-04-7.

Т-19073-19075

Б.5.- 212х.- ISBN978-99978-58-06-1.

Т-19076-19078



Тамир Э. Дорнын түүх (XVI-XXI): Сурах бичиг / Ред. Д.Оюун.- Анхны хэвл.- УБ.: Адмон, 2012.- 264х.- ISBN 978-99929-0-042-3.

Дорнын түүх (XVI-XXI) мэргэжлийн ангид үзэх сурах бичигт дорнын орнуудын шинэ ба орчин үеийн түүхийг нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд нь залгамж шинжтэйгээр, хөгжлийн загвар-хэтийн төлөв хандлага болон тулгамдсан асуудлуудыг нь харьцуулан авч үзжээ. Энэхүү сурах бичиг нь дорнын шинэ ба орчин үеийн түүхийн чиглэлээр бичигдэж байгаа анхны сурах бичиг юм. Уг сурах бичгийг

мэргэжлийн багш нар, оюутан, магистрант, докторант, түүх сонирхогчдодоо зориулжээ.

63.3(5)я73

T-20

/НУН унш-6ш/

T-18875-18876

Баярмаа Х., Идэр Д. **Дундад зууны түүх: (V-XV зууны Европ)-I** /Ред. Ц.Гантулга.- УБ.: Соёмбо принтинг, 2017. -315х. - ISBN: 978-999678-52-16-8.


“Дундад зууны түүх” сурах бичгийн гол онцлог нь бүлэг зүйлийн агуулгын хүрээнд холбогдох түүхэн эх сурвалжууд, баримт эх хэрэглэгдэхүүнээс боломжийн хэмжээгээр сонгон орчуулж, оруулж өгсөн ба тухайн үеийн үйл явдалд холбогдох түүхэн зургууд болон тусгайлан боловсруулалт хийсэн газарзүйн зураг шигтгэн оруулжээ. Энэхүү сурах бичиг их, дээд сургуульд дэлхийн түүх судалж буй оюутан, магистрантууд, ерөнхий боловсролын сургуулийн түүхийн багш нарт сургалтын чухал гарын авлага болжээ.

63.3(0)4я73

Б-38

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

T-19037-19039



Монголчууд: Харийн тамган доорх нүүдэлчид (XVII-XX зууны эхэн) /Ред. С.Чулуун. -3 дахь хэвл. -УБ.: Монсудар, 2016.-303х. -ISBN: 978-99973-1-103-0.

“Монголчууд” цуврал бүтээлийн энэ ботид Манжийн эрхшээлд өнгөрүүлсэн 300 орчим жилийн үйл явдлыг хамруулан, тухайн цаг үеийн онцлогийг тодруулах үүднээс түүхийн баримт, монголчуудын тухай жуулчдын тэмдэглэл, архивын баримт, гэрэл зургаар харуулжээ. Энэхүү бүтээлд XVII-XX зууны эхэн үе хүртэлх бүтэн гурван зууны түүхийг багтаах боломжгүй ч энэ үед хамаарах баримт, гэрэл зураг, өв соёлын дурсгалуудын зургийг ерөнхийд нь багтаасан.

63.3(1)5

M-69

/НУН унш-2ш/

T-18844-18846

Нинжбадгар 3. **Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVII-XX зууны эхэн)**

Судалгааны бүтээл /Хян. Л.Алтанзаяа.- УБ.: "Арвин судар" ХХК, 2014.-176х. - ISBN: 978-99973-823-6-8.



XVII-XX зууны эхэн үеийн Монголын түүх судлалд хутагтуудын шавь нарын асуудал чухал байр эзэлдэг билээ. Жибзундамба хутагт нь Халхын тахилын лам, эрх баригчдын нэг байсан бөгөөд хутагт, түүний шавь нарын харилцаа нь багш шавийн барилдлагаар холбогддог онцлогтой юм. Энэ бүтээлд 1639-1911 оны үед Жибзундамба хутагтын шавь нар бий болж, улмаар тэдний захиргаа нь бүрэлдэн бий болж, бэхжин, Монголын түүхэнд тодорхой нөлөө үзүүлсэн учир энэхүү үеийг сонгон “Жибзундамба хутагтын шавийн захиргаа үүсч, бэхжсэн нь”, “Жибзундамба хутагтын шавийн захиргааны үйл ажиллагаа”гэсэн 2 бүлэгт хуваан судалжээ.

63.3(1)5

H-62

/НУН унш-8/

T-19051-19052



Оюунжаргал О. **Манж Чин улсаас Монголчуудыг захирсан бодлого: Ойрадуудын**

жишээн дээр.- УБ.: Арвин судар, 2011.- 215х.- ISBN 978-99929-99-152.

Энэ бүтээлд ойрадууд Манж Чин улсад захирагдах болсон он цаг, түүхэн нөхцөлийг харгалзан үзэж Энх-Амгалан ба Найралт төв хааны ойрадуудыг захирах бодлого, Зүүнгарыг мөхөхөөс өмнө Манжид даган орсон Дөрвөд нар одоогийн нутаг буюу Улаангомд хэрхэн суух болсон, Зүүнгарыг мөхсөний дараа ойрадуудыг Хар мөрөнд нүүлгэсэн шалтгаан, Тэнгэрийн тэтгэсэн хааны “Дөрвөн ойрадыг захирах” бодлого, мөн Ховдын хязгаар бүрэлдсэн, Ховдод хуувийн сайд суулгасан зорилго, ойрад нар хэрхэн хэзээ тэнд нутаглаж, хуувийн сайдад захирагдах болсон асуудлуудыг авч үзжээ.

63.3(1)51

О-63

/НУН унш-8ш/

T-19085-19086



Хатанбаатар Ч.ба бус. **Халхын ноён хутагтууд: Намтар судлал** /Ч.Хатанбаатар, З.Нинжбадгар, Х.Мэндсайхан; Хян. д-р.,проф. Ж.Саруулбуян, З.Алтангэрэл.- УБ.: ТЭПЭ, 2014.-139х.- ISBN: 978-99973-52-25-5.

Энэ бүтээлд ноён хутагтуудын талаарх аман түүхийн мэдээ, холбогдох эх сурвалж, баримтуудад тулгуурлан Халхын ноён хутагтуудын урьд дүр мөн Монголд тодорсон есөн дүр болох Ловон Гааравдорж, Шидтэн Шавари, Ловон Шагжашэйнэн, Шидтэн Гүгүри, Агийванчүг, Лочин Бирузана, Ронсом Чойсан, Лама Шан, Нянрал Ням-одсэр, Бодон Чоглонамжил, Занён Хэрүга лам, Царчин Лосалжамц, Гэгээн Ролбийдорж, Сэр Живзүнба Чойжийжалцан, Санжаабалсан лам, Агваангончиг, Жамьяндамбийжанцан,

Лувсанжамьяанданзан, Жамьян-Ойдовжамц, Лувсанданзанравжаа, Лувсандондов, Агваанлуvsандамбийжанцан, Агваансамданжамц, Данзанлуvsантүдэв нарын намтар түүхийг өгүүлжээ.

63.3(1)-8

X-26

/НУН унш-3ш/

T-19049-19050

Баатархүү Б. **Монгол улсын тувачууд: Угсаа соёлын судалгаа** / Ред. С.Чулуун.- УБ.: Адмон принт, 2017.- 445х.- ISBN 978-99929-0-796-2.



Монгол угсаатныг бүрдүүлж буй олон угсаатны бүлгийн нэг нь түрэг хэлт Алтайн тувачууд юм. Тувачууд амьдарч ирсэн газар нутгийн онцлогоор нь Тагнын болон Алтайн хэмээн ялгадаг бөгөөд эдүгээ тэд Монгол болон ОХУ, БНХАУ-д аж төрж байна. Монгол улсад амьдарч буй тувачууд нь Алтайн тувачууд бөгөөд энэ номонд Алтайн тувачуудын угсаа гарал, нэршил, гүйцэтгэж ирсэн алба, уламжлалт аж ахуй, орон сууц, хоол унд, зан заншил, ардын дуу хөгжим зэрэг эдийн болон оюуны соёлын талаар өгүүлжээ.

63.5(1)

Б-11

/НУН унш-7ш/

T-19079-19081



Батболд Г. **Мартагдсан Пүгү аймаг: Дундад эртний Төв Азийн нүүдэлчдийн түүх, археологийн судалгааны асуудалд** / Ред. Р.Мөнхтулга.- УБ., 2017.- 244х.- ISBN 978-99978-0-465-5.

Манай улсын Төв аймгийн Заамар сумын нутгаас олдсон Монголын дундад эртний үед холбогдох Шороон Дов хэмээх бунхант булшны хэрмэн дотроос руни бичээс бүхий, тахилын мөнгөн сав, бунхнаас нь талийгаачийн намтрыг тэмдэглэсэн булшны

хятад бичээс илэрсэн нь Түрэг-Уйгурын түүхийг шинэ мэдээгээр баяжуулсан чухал баримтууд болсон билээ. Энэхүү чухал баримт, түүхийн дурсгалт олдвороос нэр нь дурдагдах төдий явсан Пүгү аймгийн тухай, түүний хүчирхэг гүрэн байсан тухайг мэдэж болох юм.

63.4

Б-33

/НУН унш-8ш/

Т-18882-18883

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Банзрагч М. **Эконометрикийн үндэс**: Гарын авлага /Ред.Г.Баттүвшин.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.-217х.- ISBN: 978-99978-4-213-8.

Эдийн засгийн мэргэжлээр суралцаж буй оюутан болон эконометрик сонирхогч багш, судлаач нарт зориулсан энэхүү гарын авлагад хос болон олон хэмжээст шугаман регрессийн загварын параметруудийн үнэлэлт байгуулах хамгийн бага квадратын арга тэдгээрийн өргөтгөлүүд, загваруудын онцлог, гетероскедастик шинж, авторегрессийн процесс, магадлалт шугаман загвар, логит болон пробит загвар, корреляцын шинжилгээ зэргийг эдийн засгийн практик хэрэглээний жишээгээр тайлбарлан авч үзжээ.

65в6

Б-25

/НУН унш-12ш/

Т-19043-19045

Алтанзаяа Г. **Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хэрэглээ**: Сурах бичиг. -Нэм.засв.2 дахь хэвл. -УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.-294х. - ISBN: 978-99962-4-242-7.

Уг сурах бичиг нь "Бизнесийн хэл болох" нягтлан бодох бүртгэлд суралцагч, ажиллагч хэн бүхэнд олж авсан суурь мэдлэгээ, глобал стандартын зүйл заалттай нийцүүлэн хэрэглэх, түүнийгээ практик хэрэглээ болгон бататгахад их, дээд сургууль, коллежийн оюутнууд болон нягтлан бодогчид, бие даан суралцагч хэнд ч тус дэм болно гэдэгт итгэж байна. Номын бүтэц нь нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ажиллаж, суралцаж буй хэн хүний хувьд глобал стандартын ерөнхий ойлголтыг авах, хэрэглээ болгох жишээ тайлбар, бодлоготой, олж авсан мэдлэгээ бататгах болон дадлагажуулах асуулт, дасгалтай байгаа нь сурах бичгийн шаардлагыг бүрэн хангажээ.

65.052я73

А-48

/НУН унш-4ш, ГНОФ-3, БС-10ш/

Т-18862-18864



Өнөржаргал А. **Компанийн дотоод аудитын онол, арга зүйн асуудал**: Нэг сэдэвт бүтээл / Ред. Л.Мөнх-Очир.- УБ.: Нью индиго, 2015.- 148х.

Дотоод аудитын мөн чанар, удирдлагад гүйцэтгэх үүргийг тодорхойлж, түүнийг компанийн хэмжээнд зохион байгуулах хэлбэр, хэрэгжүүлэх арга зүйн хүрээнд

судалгаа явуулан, өөрийн орны компаниудын дотоод аудитын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах зорилгоор хийсэн судалгааны үр дүнгээ нэг сэдэвт бүтээл болгон хэвлүүлжээ.

65.053

Ө-83

/НУН-унш-3ш, БС-10ш/

Б-24867-24868

Банк санхүүгийн Англи нэр томъёог Монгол хэлнээ орчуулан тайлбарласан толь /Хян. д-р. А.Ганзориг, д-р. Д.Батжаргал, д-р. Т.Батбаяр, д-р. Х.Буянтогтох. 2-р хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, [2017] -ISBN: 978-99973-2-770-5.



Энэхүү толь бичигт орсон нэр томъёоны тайлбарыг судалгааны ажил, заадаг хичээлийн дагуу МУИС-ийн бизнесийн сургуулийн багш, Монголбанкны ажилтан нар хамтран банк, санхүүгийн 6000 орчим англи хэл дээрхи ухагдахуун, ойлголтыг монгол хэлнээ орчуулан тайлбарлажээ.

65я2

Б-26.

/НУН унш-3ш, БС-5ш/

Т-18873-18874



Сайнжаргал Б., Наранчимэг Л. **Санхүү-эдийн засгийн шинжилгээний хичээлийн сургалтын гарын авлага, бодлого дасгалын хураамж** /3 дахь хэвл. -УБ.: МУИС хэвлэх үйлдвэр, 2017.177х.

Энэ гарын авлагад санхүү эдийн засгийн шинжилгээний практикийн хичээлээр танхимд болон оюутны бие даан гүйцэтгэх бодлого дасгалуудын үндсэн агуулга, удирдамжийг хичээлийн сэдэв тус бүрээр тодорхойлж улмаар шинжилгээний мэдээллийн эх сурвалж, хүснэгт тооцооллын үлгэрчилсэн загваруудыг аргачлал байдлаар оруулжээ. Гарын авлагыг танхимын сургалтын практикийн хичээлд

төдийгүй, танхимын дадлага, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн шинжилгээ дүгнэлт өгөхөд үлгэр болгон ашиглах боломжтой.

65.053я7

С-17

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/

Т-18870-18872

Алтанзаяа Г. **Татварын бүртгэл**: Сурах бичиг: 2-р дэв. /Хян. д-р, проф. Р.Батжаргал. –Нэмж засварл. 9дэх хэвл. -УБ.: Соёмбо принтинг, 2016.-318х. - ISBN: 978-99929-4-127-8.

Уг номонд татварыг тооцон бүртгэх болон тодорхой төрлийн татваруудын онолын ойлголт, хууль эрхзүйн заалт, түүнийг тооцох, нягтлан бодох бүртгэлээр бүртгэх, тайлагнах, татварын өмнөх ашиг, татвар ногдуулах орлогын уялдаа, тохируулгын асуудлуудыг хамаарч, сэдэв бүрд онолын ойлголт, хууль эрх зүйн заалт, түүнийг хэрэгжүүлэх тайлбар бодолт, тайлан, бүртгэлд тусгах асуудлуудыг хамрахын зэрэгцээ мэдлэг бататгах асуултууд, мэдлэг сорих тестүүд, дасгал, бодлогуудыг оруулсан байна. Энэ ном нь татварын харилцаанд өөрийнхөө хууль ёсны эрх ашгаа хамгаалах, хуулийн дагуу татвараа төлж тайлагнах замаар үүргээ хэрэгжүүлэх арга замд суралцах,



түүнийг мэдэхийг хүссэн хэн бүхэнд зориулагдсан болно.

65.261.4я73

А-48

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-16ш/

Т-18865-18867



Нямаа Д. **Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын онол, арга зүйн зарим асуудал:** Нэг сэдэвт бүтээл /Ред. д-р, проф. Б.Сайнжаргал. -УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2015. -122х. - ISBN: 978-99973-55-98-0.

Толгой болон охин компаниудыг багтаасан групп компаниудын санхүүгийн нэгтгэсэн тайланг СТОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулах, түүнчлэн санхүүгийн нэгтгэсэн тайланд шинжилгээ хийж үр дүнг шийдвэр гаргалтандаа ашигладаг болох асуудлыг шийдвэрлэх нь зайлшгүй чухал бөгөөд групп компаниудын санхүүгийн нэгтгэсэн тайлагналыг боловсронгуй болгон сайжруулахад баримтлах бодлого, горим, арга зүйн зарчмыг тодорхойлох зорилгоор хийсэн судалгааны

ажлын үр дүнгээ нэг сэдэвт бүтээл болгон толилуулжээ.

65.261

Н-98

/НУН унш-3ш, БС-10ш/

Т-18868-18869

Батжаргал Н. ба бус. **Хувь хүний санхүү:** Сурах бичиг / П.Баянсан, Д.Оюунцэцэг; Хян.Г.Бурмаа, Д.Сувдаа, Ч.Энхбаяр.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2016.- 200х.- ISBN 978-99978-0-243-9.


Энэхүү сурах бичиг нь МУИС-ийн сургалтын төлөвлөгөө, “Хувь хүний санхүү” хичээлийн хөтөлбөрийн агуулгын хүрээнд бичигдсэн бөгөөд хувь хүнд шаардлагатай санхүүгийн төлөвлөлт, тооцоолол хийх онол, арга зүйн талаар тодорхой бүлэг сэдвүүдийг агуулжээ. Энэ хичээлийг сонирхон судалж буй оюутан та өөрийн хэрэгцээт санхүүгийн мэдлэгийг олж авахын зэрэгцээ өөрийн мэдлэгт тулгуурлан санхүүгийн оновчтой, зөв шийдвэр гаргах чадварыг эзэмшиж, өөрийн амьдрал ахуйдаа бодитоор хэрэгжүүлэх боломжтой ажээ.

65.261я73

Б-33

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

Т-19061-19063



Болормаа Б., Буяндэлгэр М. **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргазүй:** Нэг сэдэвт бүтээл / Ред. Д.Доржготов.- УБ.: Ном хур, 2014.- 126х.- ISBN 978-99973-45-30-1.

Олон улсын түвшинд ашиглагдаж буй газрын харилцааны шинэ хандлагад нийцүүлэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад гарын авлага болох энэхүү номонд газар зохион байгуулалтын тухай ойлголт, зарчим, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем, түүхэн хөгжил, үе шат, Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тухайн төлөвлөгөөнд хэрэгцээт байдлын үнэлгээ ашиглах, газар зүйн мэдээллийн системд суурилсан хэрэгцээт байдлын үнэлгээний талаар өгүүлжээ.

65.32-5

Б-55

/БУН унш-6ш/

Т-19055-19056

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Эрдэнэчимэг О. Ерөнхийлөгчийн сонгуулиуд: Лавлагаа, дүн шинжилгээ /Ред. Г.Чулуунбаатар.- УБ.: Сод Пресс, 2017. -324х. - ISBN: 978-99978-0-589-8.

Монгол улсын ерөнхийлөгчийн 6 удаагийн сонгуульд манай нийгэм, улс төрийн нэр нөлөө бүхий нийт 17 хүн нэр дэвшиж, хоорондоо өрсөлдөн 4 хүн сонгогдож байжээ. Толилуулан буй энэ номонд Монгол улсын ерөнхийлөгчийн 1993-2013 оны хооронд болж өнгөрсөн 6 удаагийн сонгуулийн компанит ажиллагаа, нэр дэвшүүлэлт, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, сонгуулийн үр дүн, онцлогийг баримт материалд түшиглэн харьцуулсан дүн шинжилгээ хийжээ.




66.3(1)68

Э-73.

/НУН унш-7ш, ГНОФ-2ш/

T-19046-19048



Гэрэлт-Од Д. **Дэлхийг захирч буй эрхмүүд**: Амьдралын замнал, амжилтанд хүрсэн түүхүүд / Хян. Т.Даваасүрэн, И.Чанцал.- ЕМ publishing, 2017.- 210х.- ISBN 978-99973-0-905-1.

Энэхүү номонд эдүгээ цагийн хамгийн нөлөө бүхий 30 эрхмийн намтар бий. Жил бүр дэлхийн өнцөг булан бүрт байрлах хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн оны хүн, тэрбумтнууд болон нөлөө бүхий удирдагчдын жагсаалтыг гаргадаг. Хувьчлалаар баяжсан олигарх, төрийг лоббиддог тэрбумтан, хар тамхины бүлэглэлийн толгойлогч, аймшигт алан хядах ажиллагааг зохион байгуулагч террористыг ч энэхүү ном багтаахаа мартсангүй. Сахиусан тэнгэрүүдийн тухай биш, хүч нөлөөтэй манлайлагчын тухай өгүүлсэн.

66.3(0)-8

Г-95

/НУН-унш-4ш, ГОФ-3ш/

Б-24875-24877

НИККОЛО МАКИАВЕЛЛИ

Хунтайж

Макиавелли Н. **Хунтайж** / Ред. Б.Дөлгөөн; Орос хэлнээс орч. Ч.Баатар.- УБ.: Монсудар, 2016.- 150х.- ISBN 978-99973-1-408-6.

Сэргэн мандалтын үеийн Италийн түүхч, философич, зохиолч Никколо Макиавелли нь бүх цаг үеийн хамгийн агуу сэтгэгч,өөрийн амьдрал хувь тавиланг улс төртэй холбож тэмцсэн, зовж зүдэрсээр зорьсондоо хүрсэн суут нийгмийн зүтгэлтэн юм. Энэхүү Хунтайж бүтээлийн философи нь олон улсын харилцааны реализмын үндэс суурь болсон төдийгүй улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжилд баларшгүй ул мөр үлдээж чадсан юм. Энэхүү сонгодог зохиол урд өмнө монгол хэлнээ орчуулагдан хэвлэгдэж байсан хэдий ч энэ орчуулга, найруулгын хувьд хамгийн сайн нь болсон гэж үзжээ.

66.3(4Ита)8

M-15

/НУН-унш-7ш/

Б-24882-24884

БОЛОВСРОЛ СУДЛАЛ, СЭТГҮҮЛЗҮЙ

Мэргэжлийн боловсрол, инженерийн сурган хүмүүжүүлэх зүй /М.Гонгор,



Ц.Оюун, Ц.Содов, Л.Хишигсүрэн; Ред. Б.Өлзийхуяг. -УБ.:Соёмбо принтинг, 2017.-160х.- ISBN: 978-99978-0-464-8.

Хүн төрөлхтөн үеийн үед бий болгосон мэдлэг, боловсрол, соёл, туршлагаа дараагийн үедээ уламжлуулан үлдээж, шинэчлэн сайжруулж хөгжсөөр ирсэн билээ. Энэхүү номд дээд боловсролтой инженер-багшийг шаталсан сургалтаар дээд боловсрол-шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн холбоонд бэлтгэх сургахзүйн зарчим, онцлог, инженер-багшийг хэрхэн судлаач багш болгох, XXI зууны инженерүүдэд тавигдаж байгаа шаардлагыг тодруулан ажил олгогчдоос ажлын байрандаа тавьж буй шаардлага, профессор-багш, төгсөгчдийнхөө мэргэжлийг дээшлүүлж хөгжүүлэхэд сэтгэцийн сургах зүй, менежмент болон инновацийн асуудлыг тавьжээ.

74.5

М-97

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

T-18856-18858



Баяртогтох М. **Нэвтрүүлэгч, хөтлөгчөөр бэлтгэгдэх их дээд сургуулийн сэтгүүлзүй, тайз, дэлгэцийн урлагийн оюутнуудад зориулсан гарын авлага** /Эрхл. д-р, проф. Д.Ариун. –Анхны хэвл. -УБ.: Бит пресс, 2016.-148х. - ISBN: 978-99962-4-937-2.

Гарын авлагад сэтгүүлч-хөтлөгч хүний зайлшгүй эзэмших чадвар, монгол болон дэлхий нийтэд өргөн хэрэглэгддэг утгыг чимэх хийгээд амьсгал тохируулах, урнаар өгүүлэх гекзометрийн олон тооны аргууд, сэтгэл зүй, сэтгэцийн физиологийн 100 гаруй дасгалыг оруулсан болно.

76.03я7

Б-38

/НУН унш-4ш, ГНОФ-4ш/

T-18859-18861

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Монтескье Ш. **Хуулийн амин сүнс** / Ред. Ж.Амарсанаа; Франц хэлнээс орч. Т.Төмөрхүлэг.- УБ.: Монсудар, 2009.- 294х.- ISBN 978-99929-0-469-0.


Энэ ном анх 1748 онд хэвлэгдсэн. Уул бүтээлийг туурвихдаа зохиолч хууль бүрэлдэх шалтгаан хийгээд түүхийн талаарх өөрийн үзэл санааны тогтолцоог бичиглэх, улс төрийн эрх чөлөөний баталгааг тодорхойлох, Францын нийгэм-улс төрийн байгууллыг шүүмжлэх зорилго агуулжээ. Энэ туурвил хууль, улс төрөөр амь зуудаг, эл салбарт хүчээ үзэхийг хүсэж буй аливаа хүний оюуны сүвийг улам нээгдүүлнэ.

67.0

М-70

/НУН-унш-3ш, ГНОФ-5ш/

Б-24865-24866



Бастиа Ф. **Хууль** / Ред. Б.Батбаяр; Орч. Н.Баярбаатар.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон, 2007.- 106х.- (Монголын Либертари Сан).- ISBN 99929-5-348-9.

Францын нэрт эдийн засагч Ф.Бастиагын “Хууль” хэмээх энэ бүтээл нь түүний хамгийн сүүлчийн зохиол юм. Зохиолч удахгүй сүрьеэгээр үхэхээ сайн мэдэж байсан тул хойч үедээ гэрээслэлээ үлдээжээ. Дөнгөж буй болоод ихэд тархан олны анхаарлыг татаж, ялангуяа сэхээтнүүдийн бишрэн шүтэх болсон социализмын онол нь өнгөн дээрээ сайн сайхныг зорьсон зүйл өгүүлээд буй боловч задлан шинжлээд нарийвчлан тунгаавал хүн, түүний мөн чанар, эрх чөлөөний эсрэг хандсан гэдгийг Бастиа тэртээх 150 жилийн өмнө хүн төрөлхтөнд анхааруулжээ. Энэ зохиол Маркс Энгельс нарын “Эв хамт нарын тунхаг”-тай бараг л зэрэг бичигдсэн зохиол юм.

67.3

Б-32

/ГНОФ-7ш /

Б-24862-24864


АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Мөнхжаргал Ч. **Орхоны хөндийн аялал жуулчлал** / Ред. Ж.Долгорсүрэн .- УБ.: Амар пресс, 2017.- 124х.- ISBN 978-99978-0-341-2.

Энэхүү бүтээл аялал жуулчлалын мэргэжлээр суралцдаг оюутнууд, судлаачид, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид, хөтөч тайлбарлагчдад гарын авлага болох ач холбогдолтой болжээ. Мөн соёлын өвийн болон тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломж бүхий Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын онцлог, түүх, соёлын дурсгалууд, байгалийн үзэсгэлэнт газар тэнд орших соёлын биет бус өв зэргийг дэлгэрэнгүй судалж тусгасан байна. Соёл судлалын доктор Ч.Мөнхжаргалын судалгааны үр дүнгээр Орхоны хөндийн дурсгалт газрыг “Монголын соёлын аялал жуулчлалын жишиг бүс” болгох мөн Археологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байна гэсэн дүгнэлт гарч байна.


75.81(1)

М-817



/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

Б-24859-24861



Мөнхжаргал Ч. **Соёлын аялал жуулчлал** / Ред. Ж.Долгорсүрэн.- УБ.: Амар пресс, 2017.- 128х.- ISBN 978-99978-0-340-5.

Соёлын аялал жуулчлалыг үүсгэж байгаа эзэн ба зочин соёлын хоорондын харилцан хамаарал, тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлс, нийгмийн үүрэг, ач холбогдол, соёлын үйлдвэрлэлд үзүүлж буй үр нөлөөг өөрийн 10 гаруй жилийн хугацаанд хийсэн судалгаанд тулгуурлан гаргасанд тус бүтээлийн шинэлэг тал, практик ач холбогдол орших ажээ. Энэхүү бүтээл нь цаашид уг асуудлыг гүнзгийрүүлэн судлах эх үндсийг тавьж, аялал жуулчлалын мэргэжлээр суралцдаг оюутнууд, судлаачид, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид, хөтөч, тайлбарлагчдад гарын авлага болох ач холбогдолтой болжээ.

75.81

М-817

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

Б-24856-24858

ХЭЛ ШИНЖЛЭЛ

Монгол хэлний хадмал толь: Кирил монгол тайлбар / Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхишиг, Э.Мөнх-Учрал; Ред. Ж.Баянсан.- УБ.: Соёмбо принтинг, 2015.- 1540х.- ISBN 978-99962-2-000-5.


Энэхүү толыг бэлтгэхдээ академич Ц.Дамдинсүрэнгийн боловсруулж, эдүгээ нийтээр дагаж мөрдсөөр буй үсгийн дүрмийг баримтлан кирил үсгийн бичлэгийг жигдэлсэн бөгөөд 2011 оны 10 дугаар сард Монгол улсын Төрийн хэлний зөвлөлийн тогтоосон “Кирил бичгийн бичлэгийн стандарт”-ыг тусгасан болно. Уншигч олон нийтийн эх хэлний боловсролд тус нэмэр болно хэмээн үгийг товч тайлбарласан бөгөөд хэн хүнд утга нь илэрхий зарим үгэнд тайлбар хийлгүй, зөвхөн холбоо хоршоо үгийн жишээгээр тодруулга оруулжээ.

81-2М-4

Ч-756

/НУН унш-4ш, ГНОФ-7ш/

Б-24872-24874





Одонтуяа Л. **Орос хэлний хэлзүй** / Хян. Ч.Зэвнямбуу.- УБ.: Битпресс, 2017.- 400х.- (МУИС-ийн ШУС-ХУС).- ISBN 978-99978-4-269-5.

МУИС-ийн шинжлэх ухаан сургуулийн хүмүүнлэгийн ухааны салбар сургуулиас гаргасан энэхүү орос хэлний хэлзүйн номонд орос хэлний дүрмүүд, унших текст, ажиллах сорил дасгалыг оруулж өгсөн онцлогтой. Орос хэл сонирхон судалж буй хэн бүхэнд, их дээд сургуулийн оюутнууд, тэрчлэн орос хэлний хэлзүйг гүнзгийрүүлэн судлагсад зориулжээ.


81-2Орос-2
О-19

/НУН унш-6ш/

Б-24869-24871

Түмэнбаяр Х. **Санскрит төвд монгол толь бичиг** / Ред. Т.Баярлах, Н.Батжаргал.- УБ.: Ном бест, 2017.- 298х.- ISBN 978-99978-0-729-8.

Энэхүү санскрит төвд монгол буддын шашны түгээмэл хэрэглээний толийг санскрит төвд хэл сурч байгаа хүмүүс, мөн оюутан, лам нар, санскрит төвд хэлнээс монгол хэлнээ ном зохиол хөрвүүлэгчдэд зориулжээ. Нэрийн зүйлийг санскритаар толгойлж үг бүрийг дугаарлан бичсэн ба хайхад хялбар дөхмийг бодож төвд нэрийн хэлхээс хийж дугаарлан хавсаргажээ.



81.2Мя2
Т-78

/НУН унш-2ш/

Б-24962-24964



Улыкпан К. **Монгол-казах зүйр цэцэн үг** / Ред. У.Айбек.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 136х.- ISBN 978-99978-0-718-2.

Монгол Казахын ард түмэн бие биеийнхээ уран дүрслэлтэй ухаалаг мэргэн сургаалаас харилцан суралцахад зориулан Монгол ардын 800 зүйр цэцэн үгийг түүвэрлэн авч, казах хэлнээ хөрвүүлэхдээ тухайн цэцэн үгтэй утга ижил, уран зохиомжийн хувьд адилхан казах зүйр цэцэн үг байвал түүнийг шууд хэрэглэн, хэрэв үгүй бол монгол хэлэн дэх зохиомж, утга санааг алдуулахгүйгээр, казах хүний сэтгэхүй, ахуйд аль болох ойр ойрхон байхаар орчуулжээ.

82(1)
У-32

/НУН унш-3ш/

Б-24965-24966

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Утга зохиол / Англи хэлнээс орч. Т.Ариунсанаа, Б.Ганчимэг, С.Өнөр ба бус.-УБ.: Монсудар, 2016.- 352х.- ISBN 978-99973-1-334-8.

Дэлхийн утга зохиолын ухагдахууныг зургаар баяжуулан, хамгийн энгийнээр



